

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР ХУУЛЬ
ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 06 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Ж.Батзандан**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Хууль зүйн байнгын хороо 2014 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тус Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Д.Лүндээжанцан нар архидан согтуурахтай тэмцэх болон малын хулгайн гэмт хэрэг, хар тамхи, хүн худалдаалах, хууль бус зэвсгийн наймаа, цахим гэмт хэргийн гаралт, тэдгээрийн илрүүлэлтийн төвшин, урьдчилан сэргийлэх ажиллагаа, хүрсэн үр дүнгийн талаар асуулт асууж, хариулт авсан.

Мөн хууль зүйн салбарт гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах байгууллагыг байгуулж, чадавхижуулах зэрэг дэвшилттэй ажлууд хийгдэж байгааг дэмжихийн зэрэгцээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, авлига, хүнд сурталтай хийх тэмцэлд эрс шинэчлэл гаргах, нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, иргэний үндсэн эрхийн хяналтыг Үндсэн хуулийн цэцэд олгож иргэний үндсэн эрхийн баталгааг сайжруулах, хуулийн төсөл боловсруулах ажлын чанарт анхаарах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, тэр дундаа сүүлийн үед гарч байгаа нийтийг цочроосон, онц аюултай гэмт хэргүүдийн шалтгаан, нөхцөлийг нарийн судалж, цаашид гарахгүй байх талаас нь анхаарах, гудамж, талбайн камержуулалтын ажлыг сайжруулах нь зүйтэй гэсэн саналыг тус тус гаргасан.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ш.ТҮВДЭНДОРЖ